



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 03 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 03 дугаар хуралдааныг 2025 оны 02 дугаар сарын 05-ны зохион байгуулав.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 03 дугаар хуралдаанаар /2025-02-05/ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтийн тайлан, талаар танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 6 (Тогтоол №22-27, 2025-02-05) тогтоолыг батлан шийдвэрлэв.

Тус хуралдаанаар Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтийн тайлан, судалгаа танилцуулгыг сонсож, энэ чиглэлээр шинэчилсэн танилцуулга, шийдвэрлэх асуудлын жагсаалт, холбогдох хууль тогтоомжид оруулах хуулийн төсөл болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллахыг ӨНЗГ-ын дарга Э.Золбаяр зохион байгуулж, ажлын хэсгээс Хорооны гишүүдийг мэдээлэл судалгаагаар ханган ажиллаж, эрх бүхий дээд байгууллагад холбогдох тайлан мэдээлэл, хуулийн төсөл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хүргүүлж хамтран ажиллахыг даалгав.

ХХЗХ-ны ээлжит 03 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 6 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 6 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 22 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Очир арвай төв ХХК: Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 23 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (ВИПМК ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12

дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 24 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Сумхан чимэг ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) сунгасан;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Монтээвэр сервис ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 25 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Монтээвэр сервис ХХК: Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Юу Кэй экспресс пост ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 26 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Юу Кэй экспресс пост ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх) хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 27 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг (Ундрaм хан хангай ХХК) 2 жилээр сунган тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг [энд дарж](#) үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-02-13